

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/063/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Ц.Саранчимэг
Утас: 70272287 Цахим хаяг: saranchimeg.ts@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/119
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ү.НАРАНТУНГАЛАГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардалд 11,220.0 мянган төгрөгийн зардал гаргаж, авлага 11,476.9 мянган төгрөг, өр төлбөр 1,791.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нийт 24,488.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл байдлыг сайжруулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг тохь тухтай болгох зорилгоор хэд хэдэн арга хэмжээ авсан байна. Үүнд: Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор шинэ тоног төхөөрөмж, тавилга, хэрэгслүүдийг худалдан авч, ажлын байрыг тохижуулсан мөн албан хаагчдын

41250-260

мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор олон төрлийн сургалт, семинар зохион байгуулсан, иргэдэд үзүүлэх үйлчилгээг илүү хурдан, хялбар болгох үүднээс цахим үйлчилгээний системийг нэвтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Баяндэлгэр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилт, 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 90,0 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	225,419,668.1	141,381,140.1
33	АВЛАГА	104,060,836.0	11,476,913.1
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	725,013.0	725,013.0
335	Бусад авлага	103,335,823.0	10,751,900.0
3351	Байгууллагаас авах авлага	103,335,823.0	10,751,900.0
35	БАРАА МАТЕРИАЛ	121,358,832.1	129,904,227.1
354	Хангамжийн материал	99,050,163.1	119,214,227.1
35410	Бичиг хэргийн материал	927,136.0	803,300.0
35420	Аж ахуйн материал	37,284,584.3	43,040,984.3
35440	Түлш, шатах тослох материал	1,302,620.0	3,493,320.0
35450	Барилгын засварын материал	1,786,950.0	1,786,950.0
35460	Хүнсний материал	240,870.0	240,870.0
35470	Бусад хангамжийн материал	57,508,002.8	69,848,802.8
35500	Биологийн хөрөнгө	0.0	5,600,000.0
35600	Мал амьтад	22,308,669.0	5,090,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,599,346,620.9	2,119,145,309.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,599,346,620.9	2,119,145,309.7
392	Биет хөрөнгө	1,514,908,704.2	2,015,739,993.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,367,179,305.9	1,595,572,868.9
39202	Хуримтлагдсан элэгдэл	-415,403,293.1	-419,351,424.2
39203	Авто-тээврийн хэрэгсэл	282,755,145.0	236,585,745.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-174,413,123.8	-129,734,379.5
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	250,583,177.2	294,770,039.1
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,686,275.4	-134,758,247.1
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,905,109.5	76,167,937.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,494,058.6	-20,300,787.8
39209	Зам, гүүрний байгууламж	0.0	40,000,000.0
39214	Бусад үндсэн хөрөнгө	379,412,820.0	556,185,603.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-76,930,102.5	-79,397,361.8
393	Биет бус хөрөнгө	84,437,916.7	103,405,316.7
39301	Программ хангамж	3,095,510.0	10,095,510.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,247,593.3	-2,247,593.3
39303	Бусад биет бус хөрөнгө	83,590,000.0	95,557,400.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,824,766,289.0	2,260,526,449.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,573,619.6	1,791,362.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,573,619.6	1,791,362.0
413	Өглөг	1,573,619.6	1,791,362.0
4136	Бусад өглөг	1,573,619.6	1,791,362.0
41361	Байгууллагад төлөх өглөг	1,573,619.6	1,791,362.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,823,192,669.4	2,258,735,087.8
51	Засгийн газрын хувь оролцоо	1,823,192,669.4	2,258,735,087.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ о	190,427,442.8	190,427,442.8
51101	Өмч: - төрийн	190,427,442.8	190,427,442.8
512	Хуримтлагдсан үр дүн	1,207,441,546.7	1,642,983,965.2
51210	Өмнөх үеийн үр дүн	1,207,441,546.7	1,207,441,546.7
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	435,542,418.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	425,323,679.9	425,323,679.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,824,766,289.0	2,260,526,449.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,557,405,009.6	1,350,070,760.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	378,374,685.0	284,216,114.9
120	Нийтлэг татварын бус орлого	378,374,685.0	284,216,114.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	116,848,800.0	26,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	116,848,800.0	26,000.0
120009	Бусад орлого	4,334,300.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,179,030,324.6	1,065,854,646.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	348,047,324.6	203,047,746.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсв	223,346,917.0	182,473,560.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	124,700,407.6	20,574,186.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	830,983,000.0	862,806,900.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөв	830,983,000.0	862,806,900.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,005,798,382.2	910,031,342.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	990,430,196.2	848,285,842.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	948,856,628.1	802,981,812.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,548,987.8	495,562,392.8
210101	Үндсэн цалин	243,017,033.1	309,986,965.4
210102	Нэмэгдэл	92,696,889.1	178,986,527.4
210104	Урамшуулал	32,835,065.6	6,588,900.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,862,635.8	58,712,428.0
210201	Тэтгэврийн даатгал	31,496,348.8	39,664,807.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,705,452.7	5,318,239.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,132,506.5	2,442,197.0
210204	Ажилгүйдлийн даатгал	673,674.0	2,218,980.7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,854,653.8	9,068,202.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,359,966.4	53,173,399.4
210301	Гэрэл, цахилгаан	6,233,591.4	5,897,159.4
210302	Түлш, халаалт	47,126,375.0	47,276,240.0
2104	Хангамж, бараа материалын зардал	47,160,017.0	34,613,767.7
210401	Бичиг хэрэг	7,429,478.0	3,523,036.0
210402	Тээвэр, шатахуун	35,011,539.0	25,180,280.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,519,000.0	2,910,451.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу	1,200,000.0	3,000,000.0
2105	Норматив зардал	0.0	366,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	366,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	25,003,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	90,000.0
210604	Урсгал засвар	0.0	24,913,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,960,000.0	7,632,000.0
210702	Дотоод албан томилолт	4,960,000.0	7,632,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа	4,750,278.0	4,779,812.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээн	3,103,900.0	1,817,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	720,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	380,350.0	298,200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	349,068.0	780,492.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	196,960.0	165,000.0
210807	Газрын төлбөр	0.0	999,120.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	424,214,743.1	123,139,013.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	303,731,553.5	81,817,094.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,483,189.6	41,321,919.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,573,568.1	45,304,029.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,492,000.0	22,237,862.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	6,262,820.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан алб	0.0	14,985,042.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,492,000.0	990,000.0

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,081,568.1	23,066,167.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,081,568.1	23,066,167.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,368,186.0	61,745,500.0
2200	Дотоод эх үүсвэрээр	15,368,186.0	61,745,500.0
223001	Бусад хөрөнгө	15,368,186.0	61,745,500.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	551,606,627.4	440,039,418.5
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,107,236.2	4,497,000.0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,807,236.2	1,262,000.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-9,107,236.2	-4,497,000.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	542,499,391.3	435,542,418.5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,179,030,324.6	1,069,863,708.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,179,030,324.6	1,069,863,708.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	348,047,324.6	207,056,808.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан тө	223,346,917.0	182,473,560.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээ	124,700,407.6	24,583,248.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	830,983,000.0	862,806,900.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн тө	830,983,000.0	862,806,900.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	885,222,319.4	749,062,648.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,222,319.4	749,062,648.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	843,648,751.3	703,413,438.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,717,987.8	496,533,438.8
210101	Үндсэн цалин	244,053,142.3	309,497,567.1
210102	Нэмэгдэл	92,429,779.9	180,514,861.7
210104	Урамшуулал	32,235,065.6	6,521,010.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,862,635.8	57,741,382.0
210201	Тэтгэврийн даатгал	31,496,348.8	39,432,638.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,705,452.7	4,864,304.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,132,506.5	2,269,293.0
210204	Ажилгүйдлийн даатгал	673,674.0	2,233,130.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6,854,653.8	8,942,015.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,631,566.8	54,330,419.0
210301	Гэрэл, цахилгаан	6,233,591.4	5,897,159.4
210302	Түлш, халаалт	46,397,975.4	48,433,259.6
2104	Хангамж, бараа материалын зардал	20,136,680.0	30,637,631.7
210401	Бичиг хэрэг	2,479,880.0	3,399,200.0
210402	Тээвэр, шатахуун	10,146,000.0	20,950,980.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,519,000.0	2,987,451.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	3,991,800.0	3,300,000.0
2105	Норматив зардал	1,000,000.0	999,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	999,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.0	28,193,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	90,000.0
210604	Урсгал засвар	2,300,000.0	28,103,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,960,000.0	7,632,000.0
210702	Дотоод албан томилолт	4,960,000.0	7,632,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	7,888,278.0	5,434,812.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил	6,241,900.0	2,397,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	720,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	442,378.0	300,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	838,692.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	184,000.0	180,000.0
210807	Газрын төлбөр	0.0	999,120.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	340,151,603.0	21,911,755.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	340,151,603.0	21,911,755.0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,573,568.1	45,649,209.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,492,000.0	22,583,042.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	6,608,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан	0.0	14,985,042.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,492,000.0	990,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,081,568.1	23,066,167.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	293,808,005.2	320,801,060.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	293,808,005.2	320,801,060.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	293,808,005.2	320,801,060.0
2200	Дотоод эх үүсвэрээр	293,808,005.2	320,801,060.0
223001	Бусад хөрөнгө	261,308,005.2	70,535,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,500,000.0	250,266,060.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨ	-293,808,005.2	-320,801,060.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлд	144,833,442.8	426,608,341.0	428,961,028.8	1,000,402,812.6
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144,833,442.8	426,608,341.0	428,961,028.8	1,000,402,812.6
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	66,727,319.5	66,727,319.5
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлд	190,427,442.8	425,323,679.9	1,207,441,546.7	1,823,192,669.4
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлд	190,427,442.8	425,323,679.9	1,207,441,546.7	1,823,192,669.4
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,427,442.8	425,323,679.9	1,207,441,546.7	1,823,192,669.4
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	435,542,418.5	435,542,418.5
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлд	190,427,442.8	425,323,679.9	1,642,983,965.2	2,258,735,087.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	976,629,400.0	852,009,174.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	821,509,400.0	707,948,674.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	813,901,400.0	700,350,674.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	497,660,100.0	452,515,190.3
210101	Үндсэн цалин	286,259,300.0	309,497,567.1
210102	Нэмэгдэл	194,409,500.0	136,496,613.2
210104	Урамшуулал	16,991,300.0	6,521,010.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,207,600.0	52,597,071.0
210201	Тэтгэврийн даатгал	42,301,100.0	35,970,197.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,976,700.0	4,421,997.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,488,300.0	2,048,117.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,488,300.0	2,029,435.9
210205	Эрүүл мэндийн даатгал	9,953,200.0	8,127,323.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,057,500.0	54,330,419.0
210301	Гэрэл, цахилгаан	6,230,000.0	5,897,159.4
210302	Түлш, халаалт	75,827,500.0	48,433,259.6
2104	Хангамж, бараа материалын зардал	26,776,200.0	24,536,651.7
210401	Бичиг хэрэг	3,400,000.0	3,399,200.0
210402	Тээвэр, шатахуун	14,856,200.0	14,850,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,220,000.0	2,987,451.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	4,300,000.0	3,300,000.0
2105	Норматив зардал	1,000,000.0	999,000.0

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	999,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,500,000.0	45,579,900.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,500,000.0	17,476,900.0
210604	Урсгал засвар	30,000,000.0	28,103,000.0
2107	Томилолт, зочны зардал	7,200,000.0	7,122,000.0
210702	Дотоод албан томилолт	7,200,000.0	7,122,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,450,000.0	13,287,812.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	3,250,000.0	3,250,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	720,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.0	300,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.0	838,692.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	180,000.0	180,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,000,000.0	7,000,000.0
210807	Газрын төлбөр	1,000,000.0	999,120.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,050,000.0	49,382,630.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,050,000.0	49,382,630.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,608,000.0	7,598,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,608,000.0	7,598,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,608,000.0	6,608,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	990,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	155,120,000.0	144,060,500.0
2200	Дотоод эх үүсвэрээр	155,120,000.0	144,060,500.0
223001	Бусад хөрөнгө	155,120,000.0	144,060,500.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	976,629,400.0	852,009,174.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	976,629,400.0	852,009,174.0
132001	Орон нутгийн төсвөөс	976,629,400.0	852,009,174.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	21	21
620001	Удирдах ажилтан	5	5
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11
620003	Үйлчлэх ажилтан	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,709,699.63	238,686,510.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,709,699.63	231,170,225.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,577,934.27	189,213,262.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,979,989.66	59,435,185.03
210102	Нэмэгдэл	33,979,989.66	59,435,185.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,279,341.61	6,653,597.00
210201	Тэтгэврийн даатгал	2,818,772.73	4,593,675.00
210202	Тэтгэмжийн даатгал	331,620.33	596,477.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	504,785.84	298,271.00
210204	Ажилгүйдлийн даатгал	56,742.05	233,054.00
210205	Эрүүл мэндийн даатгал	567,420.66	932,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	6,100,980.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	6,100,980.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	510,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	510,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	1,147,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	300,000.00	1,147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309,018,603.00	115,366,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	309,018,603.00	115,366,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,131,765.36	41,956,962.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	23,740,021.50

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан	0.00	23,740,021.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,131,765.36	18,216,941.49
213405	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан	23,131,765.36	18,216,941.49
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	7,516,285.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	7,516,285.00
223001	Бусад хөрөнгө	0.00	7,516,285.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	370,709,699.63	238,686,510.02
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	370,709,699.63	238,686,510.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвө	233,708,492.00	208,154,761.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	137,001,207.63	24,583,248.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		5,948,500.52
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		5,948,500.52

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 223,660.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлангаарх хөрөнгийн зардал үндсэн хөрөнгийн худалдан авсан хөрөнгийн дүнгээс 216,660.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт оруулан үр дүнг тооцдог цахим программ лицензийн төлбөр 7,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, хөрөнгийг орлого аваагүй тайлагнасан.
- ЗДТГ-ын газар эзэмших эрхийн 6 газрын суурь үнийг зөрүүтэй бүртгэсэн, 76 мкв газар давхардсан газрыг илүү бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 233,613.9 мянган төгрөгийн зөрчлөөс 14,474.9 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 736.7 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 233,613.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 14,474.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 62,539.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 156,600.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

Залруулаагүй алдаа:

Төлбөрийн акт

1. Сумын Засаг даргын орлогчид ажлаас чөлөөлөгдсөний 6 сарын тэтгэмжийн зардал 11,220.0 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Дуудлага худалдааны орлогыг 1,339.8 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, орон нутгийн орлогоос өмнөх онд илүү санхүүжүүлсэн 416.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 23 дугаар зүйлийн 23.8.14-д “газрын төлбөр төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

3. Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журмын дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 2 албан хаагчид олгосон мөнгөн урамшуулал 14.985.0 мянган төгрөгөөс 1,498.5 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож аваагүй олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 22 дугаар зүйлийн 22.1.1-д “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Баяндэлгэр сумын 2024 оны төсөв баталсан ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 39 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар шилжих үлдэгдлээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа ЗДТГ-ын хатуу эдлэл буюу техник тоног төхөөрөмж авах зардалд 40,000.0 мянган төгрөг батлагдсан байтал компьютер, принтер гэх мэт тоног төхөөрөмж 62,500.0 мянган төгрөгөөр тендергүйгээр худалдан авалт хийсэн байна. Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна”, 34 дүгээр зүйлийн 34.1-д “Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага тогтоов.

2. Баяндэлгэр сумын ЗДТГ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг өмнөх онд байршуулаагүй тул зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн шилэн дансны зарчим 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-д “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэсэн заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг ойлгомжтой, бүрэн, хугацаанд нь байршуулж, оруулах мэдээлэл байхгүй гэж илгээдэг алдааг давтан гаргахгүй байхад анхаарал хандуулан байгууллагын дотоод хяналтыг шилэн дансны үйл ажиллагаанд үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмж

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой

Илрүүлэлт:

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 39 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар "2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт /шилжих үлдэгдэл/" гэж баталсан боловч нэг ч барилга байгууламж хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тусгагдаагүй урсгал зардал, техник тоног төхөөрөмжийн жагсаалт баталжээ. Мөн түүнчлэн "ЗДТГ-ын хатуу эдлэл" гэсэн нэрээр яг ямар зориулалттай тодорхойгүй 40,000.0 мянган төгрөг, нэр зааж заагдаагүй зардал 15,000.0 мянган төгрөг, бусад гэсэн 24,700.0 мянган төгрөг баталсан нь нэр томъёоны хувьд болон агуулгын хувьд тодорхойгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.2.6.в-д “Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөл дэх төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хамаарах өөрчлөлт нь энэ хуульд заасан төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагыг хангасан байх”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.6.6-д “сум, дүүргийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулан, дараах зүйлийг тусгана” гэснийг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын төсөв батлах тогтоолд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн зэргийг тодорхой зааж тогтоолд оруулан өмнөх зөрчлийг давтан гаргахгүй байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой		Үүнээс	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Залруулсан	дүн
1	Цахим программыг биет бус хөрөнгийн орлогоор бүртгэж аваагүй байна.	1	7,000.0	1	7,000.0			1	7,000.0
2	Мөнгөн гүйлгээний тайлангаарх хөрөнгийн зардал үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас зөрүүтэй тайлагнасан.	1	216,660.9			1	216,660.9	1	216,660.9
3	Газар эзэмших эрхийн газрын суурь үнийг зөрүүтэй бүртгэсэн мөн газар эзэмших шийдвэргүй газрыг бүртгэсэн байна.	1	530.6			1	530.6	1	530.6
Нийт дүн		3	224,191.5	1	7,000.0	2	217,191.5	3	224,191.5

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Техник тоног төхөөрөмж 62.5 сая төгрөгөөр тендергүйгээр худалдан авалт хийсэн байна.	1	62,539.1			1	62,539.1		
2	Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар дээрх тогтоолд зориулалттай тодорхойгүй, нэр заагдаагүй, бусад гэсэн нэрээр 24.7 сая төгрөг баталсан	1	156,600.0					1	156,600.0
3	Сумын Засаг даргын орлогчид ажлаас чөлөөлөгдсөний 6 сарын тэтгэмжийн зардал олгосон.	1	11,220.0	1	11,220.0				
4	Төсөвт төвлөрүүлэх орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	1,756.4	1	1,756.4				
5	Мөнгөн урамшууллаас ХХОАТ-ыг суутган тооцож аваагүй олгосон байна.	1	1,498.5	1	1,498.5				
6	Шилэн дансанд мэдээллийг байршуулаагүй зөрчлийг давтан гаргасан байна.	1	-			1	-		
Нийт дүн		6	233,614.0	3	14,474.9	2	62,539.1	1	156,600.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn